ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ

2017

ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Алсын хараа, Эрхэм зорилго, Зорилтууд, Үнэт зүйлс
- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Компанийн түүх
- Зах зээлийн өнөөгийн байдал

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Төлөөлөн удирдах зөвлөл, түүний зохион байгуулалт
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- Байнгын хороод
- Компанийн засаглалыг сайжруулах хөтөлбөр
- Ногдол ашгийн бодлого
- Хувьцааны мэдээлэл
- Гүйцэтгэх удирдлагын баг

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Үндсэн үйл ажиллагаа
- Үйл ажиллагааны хураангуй
- Онцлох үйл явдлууд
- Их болон урсгал засвар
- Төсөл хөтөлбөр

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Эдийн засагт чиглэсэн үйл ажиллагаа
- Байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагаа
- Нийгэм ба хувь хүний хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа
- Нийгмийн хариуцлага
- Шагнал
- Түнш байгууллагууд

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- Аудитын дүгнэлт
- Санхүүгийн тайлан

ХААН БАНК
Экспресс Банк
ОЛОН УЛСЫН
РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ
SAMSUNG
SKYtel
MNT
ГАР УТАС, СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН
ХУДАЛДААНЫ ТӨВ

АЛСЫН ХАРАА

Дэлхийд өрсөлдөхүйц бизнес, үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн салбарт тэргүүлэгч компани болж, Монгол улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бизнесийн хамтрагч, түнш, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, ажиллагсдын хувьд үнэ цэнэтэй компани болоход оршино.

ҮНЭТ ЗҮЙЛ

- Ес зүйтэй, хууль эрх зүйд нийцсэн шударга үйл ажиллагааг эрхэмлэнэ.
- Ажилтан бүр тэгш эрхтэй, хариуцлагатай, бие биеэ хүндэтгэж, чин сэтгэлээсээ ажиллана.
- Үйлчилгээ, үйл ажиллагаа бүрээр хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг дээд зэргээр хангана.
- Харилцагч түншүүд, нийгэм, хүрээлэн буй орчиндоо тустай үйл ажиллагаа эрхэлнэ.
- Бизнесийн тогтвортой өсөлтийг хангаж байнга хөгжигч байна.

ЗОРИЛТ

- Хууль ёс, компаний үнэт зүйлсийг эрхэмлэн дээдлэх,
- Компанийн засаглалыг хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг нэмэгдүүлэх, ил тод, нээлттэй тайлагналын тогтолцоог нэвтрүүлэх,
- Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулах,
- Үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх,
- Олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэх,
- Шинэ дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх,
- Хүний нөөцийн бодлого, ажиллагсдын нийгмийн асуудлыг хангах
- Нийгмийн хөгжил сайн сайханд бодитой хувь нэмэр оруулах

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

ХУРААНГУЙ:

- Өнгөрсөн жил улс орны эдийн засгийн байдал өмнөх жилтэй харьцуулахад сайжирсан боловч, энэ нь үл хөдлөх хөрөнгийн салбарт нөлөө багатай байлаа.. Хэдийгээр нөхцөл байдал сайнгүй байсан ч Та бүхний дэмжлэгтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон компанийн хамт олны үр бүтээлтэй хамтын ажиллагааны үр дүнд компани 2017 онд тавьсан зорилтоо хэрэгжүүлж чадлаа.
- Компанийн болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанийн болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ирлээ.
- Төлөөлөн удирдах зөвлөлийг бизнесийн ажлын өргөн мэдлэгтэй, мэргэжлийн туршлагатай хүмүүсээр бүрдүүлж, зохистой гүйцэтгэх удирдлагаар хангаж ажиллаж ирсэн нь компанийн сайн засаглалыг хөгжүүлэх, ил тод тайлагнал, нээлттэй шуурхай байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Үүний зэрэгцээ компанийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх ажлуудад анхааран ажиллалаа.

Эрхэм хүндэт Хувьцаа эзэмшигчид, харилцагчид, гадаад дотоодын бизнесийн түншүүд Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Та бүхэнд Тахько (ХК) компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.Тахько (ХК) компани нь 1992 онд хувьчлагдсан үеэс хойш 20 гаруй жил тасралтгүй бизнесийн үйл ажиллагаа эрхэлж ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар үл хөдлөх хөрөнгийн түрээс, түүнтэй холбоотой үйлчилгээ болон хөрөнгө оруулалт, шинэ төсөл хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Өнгөрсөн жил улс орны эдийн засгийн нөхцөл байдал өмнөх жилтэй харьцуулахад сайжирсан боловч, үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын борлуулалт, ашгийн үзүүлэлтэнд төдийлөн ахиц өөрчлөлт гараагүй юм. Хэдийгээр нөхцөл байдал сайнгүй байсан ч Та бүхний дэмжлэгтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон компанийн хамт олны үр бүтээлтэй хамтын ажиллагааны үр дүнд компани 2017 онд тавьсан зорилтоо хэрэгжүүлсэн жил боллоо.

Компанийн болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанийн болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж, Монголын хөрөнгийн биржээс тавьсан шалгуур үзүүлэлтийг амжилттай биелүүлж ирсний дээр үүсгэн байгуулагдсанаас хойш хувьцаа эзэмшигчдэд тогтмол ногдол ашиг хуваарилж ирсэн билээ. Өнгөрсөн 2017 онд 2016 оны цэвэр ашгаас нийт 623 хувьцаа эзэмшигчдэд128,518.2 мянган төгрөгийн ногдол ашиг хуваарилан олголоо.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд өргөн цар хүрээний мэдлэг, тал бүрийн туршлагатай байх нь компанийг зохистой удирдлагаар хангаж, үр дүнтэй, оновчтой бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг билээ. Иймд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бизнесийн ажлын өргөн мэдлэгтэй, мэргэжлийн туршлагатай хүмүүсээр бүрдүүлж, зохистой гүйцэтгэх удирдлагаар хангаж ажиллаж ирсэн нь компанийн сайн засаглалыг хөгжүүлэх, ил тод тайлагнал, нээлттэй шуурхай байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг урт хугацаанд өсгөж арвижуулахын тулд компанийн өөрийн дотоод нөөц бололцоон дээр тулгуурлаж, туршлагатай мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлж ажиллахын зэрэгцээ нийгмийн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй бизнесийн үйл ажиллагаа явуулахыг цаг үргэлж хичээдэг болно.

Цаашид Тахько (ХК) компанийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах үүднээс илүү өргөн цар хүрээнд бусад салбарт мөн хүч сорихоор зорьж байна. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд шинэ бизнесийн боломжийг эрэлхийлж тодорхой төсөл хэрэгжүүлэх урьдчилсан судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж байна.

Ирэх жилүүдэд бодож төлөвлөсөн ажлуудаа тууштай үргэлжлүүлж, олсон амжилтаа бататгаж бэхжүүлэхийн төлөө анхаарч ажиллахын зэрэгцээ орчин үеийн хурдтай тэлж буй бизнесийн салбарын хөгжлөөс нэг алхмын урд байж шинийг эрэлхийлж, боломж бололцоог бий болгож, бодит үр дүн гаргахын төлөө ажиллах болно.

Манай компанийн үйл ажиллагааг байнга дэмжин, итгэл хүлээлгэн хамтран ажилладаг нийт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, ажил хэргийн түншүүд, компанийн хамт олонд Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлэхийн ялдамд ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Та бидний хамтын бүтээлч үйл ажиллагаа улам өргөжин тэлж, хөгжин дэвшихийн ерөөлийг дэвшүүлье.

Хүндэтгэсэн,

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Л. БУЯНБАТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

ХУРААНГУЙ:

- Компанийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор түрээсийн гэрээнүүдийн хугацааг сунгаж, компанийн үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, түрээсийн орлогыг тогтвортой байлгах нөхцөлийг бий болголоо.
- Компанийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)–ын дагуу гаргаж, PwC аудит компаниар олон улсын түвшний бүрэн хэмжээний хараат бус аудит хийлгэн дүгнүүлснээр цаашид компанийн санхүүгийн тайланг олон улсын жишгээр тайлагнаж байх суурийг тавилаа.
- Компанийн нийт үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Үнэлгээний олон улсын стандартын дагуу үнэлүүлэх ажлыг хийлгүүлж, үл хөдлөх хөрөнгийн бодит байдалд нийцүүллээ.

Эрхэм хүндэт Хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түншүүд, ажиллагсад аа,

Та бүхэнд компанийн үйл ажиллагаа, хамт олныхоо ололт амжилтын талаар танилцуулахад таатай байна.

Сүүлийн жилүүдэд манай компанийн хувьд амжилт бүтээлээр дүүрэн, хөгжиж дэвшсэн он жилүүд байсан ба 2017 он ч бидний хувьд мөн л амжилтаар дүүрэн жил болж өнгөрсөн бөгөөд компанийн татварын дараах ашиг өмнөх жилээс 48 хувиар нэмэгдлээ. Өнгөрсөн жил компанийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор Мобиком корпораци ХХК–тай байгуулсан түрээсийн гэрээг 5 жил, Ньюком проперти ХХК, Скайтел ХХК–тэй байгуулсан түрээсийн гэрээнүүдийг тус тус 3 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн сунгаснаар компанийн үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, түрээсийн орлогыг тогтвортой байлгах нөхцөлийг бий болголоо.

2017 оны компанийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)–ын дагуу гаргаж, PwC аудит компаниар олон улсын түвшиний бүрэн хэмжээний хараат бус аудит хийлгэн дүгнэлт гаргуулж, түүнийг Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлснээр санхүүгийн тайланг олон улсын жишгээр тайлагнаж эхэлсэн Монголын хувьцаат компаниудын нэг болж чадлаа.

Бид Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу Гэгэрэ Эстимэйт ХХК–аар компанийн нийт үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Үнэлгээний олон улсын стандартын дагуу үнэлүүлэх ажлыг хийлгүүлж, жилийн эцсээр данс бүртгэлд тусгалаа. Үнэлгээнд орлого, өртгийн хандлагуудыг ашигласан бөгөөд Монгол улсын эдийн засгийн байдал, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн байдал, түрээсийн зах зээлийн өнөөгийн үнэ, хандлага, зах зээлийн нийлүүлэлт, эрэлт зэргийг компанийн үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг өнөөдрийн бодит байдалтай нийцүүллээ. Цаашид ч бид энэ чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах болно.

Компанийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах зорилгоор жил бүр тогтмол хийдэг ажлуудын нэг бол их болон урсгал засварууд юм. 2017 онд энэ ажлын хүрээнд МА–II барилга (Теди төв)–ын барилгын 3,4 дүгээр давхрын цонх солих, U–I барилгын фасадыг хөөсөн хавтангаар өнгөлж дулаалах, дээврийн парпет, цонхны усны хаялга, төмөр тавцан хийх их засварын ажлуудыг хийж капиталжуулсан юм. Түүнчлэн, МА–II барилгын 1 дүгээр давхрын агааржуулалтын системийг өөрчлөх, Гурвалжин дахь аж ахуйн хашааны талбай, харуулын байр, цахилгааны дэд өртөө байгуулах, Анкор төвийн барилгад кондейшн, хулгайн дохиолол тавиулах, цахилгаан болон сантехникийн урсгал засвар, дотоод тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн юм.

Компанийн ажилтнуудын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, сургалтанд хамруулах, ажилтнуудын ажиллах орчинг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулах, оёдлын үйлдвэр, компанид ажиллаж байсан ахмад настнууд, хөдөлмөрийн баатар, ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, тусламж дэмжлэг үзүүлэх зэрэгт онцгой анхаарал хандуулан ажиллалаа.

Нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Анкор төвд НҮБ, Дэлхийн зөн ОУБ, Мобиком корпораци ХХК, Улаанбаатар ротари клуб, Wash action of Mongolia ТББ, Гэр иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв, Нутгийн шийдэл сан, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамрын газар, Монголын урлагийн зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран хурал, семинар, сургалт, уралдаан тэмцээн зэрэг нийгэмд чиглэсэн арга хэмжээнүүдийг үнэ төлбөргүй зохион байгуулж дэмжлэг үзүүллээ.

Цаашид ч бид даяарчлагдаж буй дэлхийн хөгжилтэй , түншүүд, харилцагч нартайгаа хөл нийлүүлэн алхаж, салбартаа шилдэг, тав тухтай тохилог үйлчилгээг үзүүлдэг компанийн нэг болж, хамгийн сайн засаглалын тогтолцоотой байж, ил тод байдлыг бэхжүүлэн ажиллахаа илэрхийлж байна.

Та бүхэнд хамт олныхоо нэрийн өмнөөс чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлж, ирээдүйн ажил үйлсэд амжилт хүсье.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Л. ЭНХНАСАН

КОМПАНИЙН ТҮҮХ



1931
Монгол улсад анхны оёдлын артель байгууллагдав.

1951
Улаанбаатар хотын оёдлын 6 дугаар артель болж өргөжив.

1970
Улаанбаатар хотын оёдлын фабрик болж шинэчлэгдэв.

1972
Оёдлын үйлдвэрийн нэгдлийн Оёдлын үйлдвэрийн нэгдэл байгуулагдсан.

1991
Оёдлын үйлдвэрийн нэгдэл татан буугдсан тул Тахь пүүс байгуулагдав.

1992
Тахько (ХК) компани болж өөрчлөгдөн байгуулагдсан.



Ньютел ХХК–тай одоогийн оффисын байрны 1, 2 давхарын анхны түрээсийн гэрээ байгуулав .

2004–2005

Тэди төвийн барилгыг 2004 оноос 10 жилийн хугацаагаар түрээслэх гэрээ байгуулав.

2004–2014

Мобиком корпораци ХХК, Ньюком проперти ХХК, Скайтел ХХК–тай түрээсийн гэрээг байгуулав.

2014

Үйлчилгээний зах зээлийн хэрэгцээнд тулгуурлан Анкор төвийг шинээр нээлээ.

2015

Мобиком корпораци ХХК, Ньюком проперти ХХК, Скайтел ХХК–тай түрээсийн гэрээг байгуулав.

2017

ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ОФФИСЫН ЗАХ ЗЭЭЛ

Улаанбаатар хотын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн нэг том хэсэг бол оффисын зах зээл юм. 2017 оны 6 дугаар сарын байдлаар зах зээл дээр нийт 1,118 сая ам дөрвөлжин талбай ашиглагдаж байгаа бөгөөд үүнээс одоогоор 189.2 ам дөрвөлжин талбай хоосон байна гэсэн тойм судалгаа байна.

Улаанбаатар хотод буй нийт оффисыг дүүрэг дүүргээр харвал нийт зах зээлийн 49% буюу 102 оффис нь Сүхбаатар дүүрэгт, 36 буюу 17% нь Чингэлтэй дүүрэгт байна. Нийслэлийн оффисын барилгуудыг байршил, хийц, хэмжээ, түрээслэгчид болон түрээсийн менежментийн байгаа байдлаар нь 3 бүлэгт хуваан авч үзэхэд 14.3% нь А зэрэглэл, 55% нь В зэрэглэлд байгаа бол 30.6 % нь С зэрэглэлд хамрагдаж байна.

Нийт зах зээл дээр байгаа оффис талбайн 77.4% түрээслэгдэж байгаа бол 22.6% нь борлуулагдаж байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд ойролцоогоор нийт 40000 м.кв талбай бүхий оффисын барилгууд зах зээлд шинээр нэмэгдсэн боловч нийлүүлэлт илүүдэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд зах зээлийн орчин эдгээр барилгуудын эрэлт бага байгаа тул амжилттай болж чадаагүй хэвээр байна. 2017 оны оны 4-р улиралд оффисын зах эргэн сэргэх хандлагатай болсон бөгөөд түрээсийн үнэ 2016 оны мөн үеийнхээс 2.30 хувиар, худалдаалах үнэ урьд оны мөн үеийнхээс 0.46 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ сэргэлт 2018 онд аажмаар өсөх хандлатай байна.

НИЙЛҮҮЛЭЛТ

Хотын төвийн А бүс дахь оффисын нөөц өнгөрсөн нэг жилийн хугацаанд 30 гаруй хувиар огцом өслөө. Зах зээл дээр гарч ирсэн эдгээр шинэ оффис нь эдийн засаг эрс удаашрахаас өмнө амжаад барилгын ажил нь ерөнхийдөө дууссан байсан барилгууд юм.

Харин барилгын бусад олон төсөл хөрөнгө оруулалтын орчин муудсан энэ үед явц дундаа зогссон байдалтай байна. Зах зээл дахь оффисын талбайн нөөцийн хэмжээ 2015 онд өмнөх жилийн урьдчилсан таамаглалд гарсан хэмжээндээ хүрсэн юм. Харин олон барилгын зогсонги байдлын улмаас 2016 оны тухайд хийгдсэн таамаглал өмнөх жил 759,000 м.кв байсан бол одоогоор 686,000 м.кв болж буурахад хүрээд байна.

2018 он дуусах хүртэл зах зээлд нийлүүлэгдэх оффисын талбайн хэмжээ м.кв

	2018 (Т)
А Зэрэглэл	175,537
Б Зэрэглэл	466,730
С Зэрэглэл	216,073
Нийт	858,340

Эх сурвалж: ЭмЖиПи, Эй Пи Ай Пи

ОФФИСЫН БАРИЛГЫН ДҮҮРГЭЛТ

Оффисын зах зээлд 2013 онд үүссэн сөрөг хандлага 2016, 2017 оны туршид үргэлжилсэн. Оффис дүүргэлтийн хувь салбарын бүх хэсэгт буурсаар байсан ба энэ нь А зэрэглэлийн оффист хамгийн ихээр ажиглагдсан. Жилийн өмнө А зэрэглэлийн оффис түрээслэгчид илүү хямд, зэрэглэл доогуур оффисууд руу шилжсэнээр доогуур зэрэглэлийн оффисуудад эерэг нөлөө үзүүлсэн.

Оффисын дүүргэлт жилээр болон хувиар

с	2016	2017 (3р улирал)
А зэрэглэл	50%–60%	60%–65%
В зэрэглэл	75%–85%	75%–80%
С зэрэглэл	75%–85%	80%–85%

Эх сурвалж: ЭмЖиПи, Эй Пи Ай Пи

Дүүргэлт оффисын зэрэглэлээр

55%	80%	80%
А зэрэглэл	В зэрэглэл	С зэрэглэл

Эх сурвалж: ЭмЖиПи, Барилга.мн

ТҮРЭЭСИЙН ҮНЭ ХАНШ

Монголын ипотекийн корпорацийн 2017 оны 2-р улирлын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтийн тайланд мэдээлснээр оффисын байр дунджаар 1 мкв-ыг 3.53 сая төгрөгөөр худалдаалагдаж байна. Оффисын түрээсийн үнэ дүүргээс шалтгаалан 1 мкв нь 15–29 мянган төгрөгийн хооронд байгаа ба хамгийн өндөр дундаж түрээсийн үнэтэй нь Сүхбаатар дүүрэг байна.

Мастер пропертийс зуучлалын компанийн оффисын үнийн таамаглалыг дор харуулав.

Улаанбаатар хотын оффисын 1м2 талбайн худалдах үнийн таамаглал, 2004–2025 он, мянган төгрөгөөр:



Эх сурвалж: http://www.master.mn/content/read/146.htm

Оффисын худалдах дундаж үнийг 2017 онд ойролцоогоор 4.1 сая төгрөг, А зэрэглэлийн оффисын худалдах үнийг 6.8 сая төгрөг гэж таамагласан байна.

Орон сууцны түрээсийн үнийн хувьд Чингэлтэй дүүрэг хотын төвийн байршлаас шалтгаалж Сүхбаатар дүүргийн дараа орж байгаа бөгөөд түрээсийн үнэ 2013 онд хамгийн өндөр буюу 18,430 төгрөг хүрч байсан боловч өдгөө 14,420 төгрөг болж буурсан байна. Чингэлтэй дүүрэг дэх түрээсийн өгөөж дунджаар 13.4% буюу хамгийн өндөр байна.

Ойрын ирээдүйд тус дүүрэгт шинэ барилга, орон сууцны төсөл хэрэгжих төлөвлөгөө тусгагдаагүй зэргээс улбаалж тус дүүргийн түрээсийн өгөөж өсөх хандлагатай байна.

Доор өгөгдсөн түрээсийн үнэ нь хотын тодорхой нэг бүс дэх тодорхой нэг зэрэглэлийн оффисын үнийн хандлагыг илэрхийлэх зорилготой юм. Бодит байдал дээр түрээсийн үнэ нь хэлбэлздэг ба талууд хоорондоо хийх хэлэлцээр дээр тулгуурлаж болох юм. Түрээсийн үнийг нэг сарын үнээр, америк доллараар үзүүлсэн болно.

Оффис түрээсийн дундаж үнэ



Эх сурвалж: Мастэр Пропертис, YCXороо

Зарим оффис барилгуудын үнэ ханш зэрэглэлээр болон байршлаар

Үнэ ам.доллар	Тайлбар	Жишээ			
		Барилга	Үнэ ам.доллар	Зэрэглэл	Байршил
35–40	Дээд зэрэглэл	Централ таур	40	A	CBD
		Блү Скай	40	A	CBD
25–35	Өндөр үнэлгээ бүхий B–р зэрэглэл	Твин Таур	26	B	Сөүлийн гудамж
		ЭнСиПи	26	B	CBD
20–25	Олонд танигдсан B зэрэглэл	М плаза	25	B	Баруун сэлбэ
		Пийс цамхаг	21	B	Их дэлгүүр
		Шонхор цамхаг	23	B	CBD
20 оос бага	Сайн байрлалтай хуучин барилгууд	MN Таур	17	C	Баруун сэлбэ
		Макс таур	19	C	Их дэлгүүр
		Метро бизнес төв	18	C	Бага тойруу

Эх сурвалж: ЭмЖиПи, Эй Пи Ай Пи

ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ЗАХ ЗЭЭЛ

Улаанбаатар хотын төвд А бүсийн зэрэглэлийн худалдаа, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө түрээслүүлэх болон худалдах үнэ ханш буцан сэргэх хандлага ажиглагдаж эхэлж байна.

Харин залуучуудад зориулсан түргэн хоолны болон кофе шопны олон улсын брэндүүд олноор нээгдэж өргөжин тэлсээр байна.

Үл хөдлөх хөрөнгө хувьчлагдах үеэс иргэд зам дагуу байрлах нэг давхрын орон сууцаа гадагш гудамж руу өргөтгөж үйлчилгээний байр болгож эхэлснээр одоогийн худалдааны гол гудамжууд бий болсон. Ойролцоогоор 5км үргэлжлэх худалдааны төв гудамжуудад өнгөрсөн жилийн хугацаанд нийт 80 орчим байрны түрээслэгч солигдсон байна. Үүнд 25-аас дээш хувь нь нийтийн хоол ундааны газрууд байв. Өнгөрсөн нэг жилийн дотор түрээслэгч нь 2 удаа солигдсон байр дор хаяж 3 байснаас 2 нь нийтийн хоол ундааны газрууд байсан байна. Худалдаа үйлчилгээний мкв талбайн түрээс хамгийн өндөр байдаг Е.С. Цэрэндоржийн буюу Усан оргилууртай гудамжинд түрээслэгчид хамгийн ихээр солигдон шинэчлэгддэг ба эдийн засгийн удаашралтай өнөө үед энэ гудамжинд үйлчилгээний олон байр хоосон байна.

Худалдааны төвүүд (үйл ажиллагааны чиглэлээр)

Үйл ажиллагааны төрөл	2015	2016
Нийтийн хоолны чиглэл	221	216
Хувцас болон гэр ахуйн	128	96
Эрүүл мэнд, гоо сайхан	104	106
Банк	34	36
Бусад	153	190

Эх сурвалж: ЭмЖиПи, Эй Пи Ай Пи

Төв худалдааны гудамжууд дахь үйлчилгээний нэр төрлийн хуваарилалтад 2014 оны нэгдүгээр улирлаас хойш мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдсангүй. Хүснэгтэд багтсан “Бусад” гэсэн нэр төрөлд супермаркет, бөс бараа, амьд цэцэг гэх мэт төрөлжсөн барааны дэлгүүр, мөн хоол,ундаа, гоо сайхны салон хоёроос бусад үйлчилгээний газар багтана.

	Нийтийн хоолны чиглэл	Хувцас болон гэр ахуйн	Эрүүл мэнд гоо сайхан	Банк	Бусад
Цэрэндоржийн гудамж	18	12	12	2	16
Сөүлийн гудамж	31	9	13	10	19
Баруун сэлбийн гудамж	25	17	15	1	21
Энх тайвны өргөн чөлөө баруун	8	8	6	1	13
Энх тайвны өргөн чөлөө гол хэсэг	16	20	15	6	6
Энх тайвны өргөн чөлөө төв хэсэг	18	17	21	4	26
Бага тойруу	62	4	18	3	41

Эх сурвалж: М.А.Д

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ ХАНШ

Төв худалдааны гудамж дахь худалдаа, үйлчилгээний зориулалттай байрны 1 м.кв-ын үнэ өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 20 хүртэлх хувиар буурсан байна. Худалдааны гудамж болон их дэлгүүрүүдэд түрээсийн үнэ мөн адил уналттай байсан, гэхдээ хотын төвийн Энхтайваны гудамж болон өндөр зэрэглэлийн их дэлгүүрт түрээсийн үнийн бууралт харьцангуй бага байна.

Түрээсийн болон худалдаалах үнэ (ам.доллар)

Гудамжны нэр	Түрээсийн үнэ (нэг м2)	Худалдаалах үнэ (нэг м2)
Цэрэндоржийн гудамж	25-30	3400-3800
Энх тайвны өргөн чөлөө төв хэсэг	24-29	3200-3600
Энх тайвны өргөн чөлөө гол хэсэг	19-24	3200-3600
Сөүлийн гудамж	20-25	2400-2800
Ард кино театр	15-20	2800-3200
Энх тайвны өргөн чөлөө баруун	14-19	2300-2700
Баруун сэлбэ	12-17	2300-2700
Бага тойруу	8-12	1700-2100

Эх сурвалж: М.А.Д

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөл байна.

Тахько (ХК) компанийн дүрэмд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, үүний 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүнээс бүрдэх бөгөөд компанийн үйл ажиллагааны стратеги, бодлого, менежментийг тодорхойлох, компанийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх, Гүйцэтгэх удирдлагын үр дүнтэй үйл ажиллагааг хангах, компани болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг гүйцэтгэж, хувьцаа эзэмшигчдийн өмнө хамтын хариуцлага хүлээж ажилладаг.

Компанийн бизнесийн стратеги болон тулгарч буй эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцооны үйл ажиллагааг жилд хамгийн цөөндөө хоёроос доошгүй удаа хянан хэлэлцэж, шаардлагатай шийдвэрүүдийг гарган ажилладаг.

Одоо ажиллаж байгаа Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь 100 хувь компанийн засаглалын сургалтад хамрагдаж, Компанийн тухай хуульд заасан болзол, шаардлагыг хангасан хүмүүсээс бүрдсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн өдөр тутмын дотоод үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан ажилладаг.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тахько (ХК) компанийн бүтэц, засаглалын тогтолцоо нь Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, Компанийн дүрмээр тодорхойлогдож, Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр, дүрэм, журам, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тахько (ХК) компанийн дүрэм (Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар батлагдсан)-д зааснаар Компанийн засаглалын эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байдаг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөл ажилладаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх байнгын хороодтой ажиллаж байгаа бөгөөд тэдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэж, аудитын, цалин урамшууллын байнгын хороодын даргаар хараат бус гишүүд ажиллаж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх асуудал, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороодыг байгуулах, тэдгээрийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох асуудал хууль, дүрэмд зааснаар ил тод явагдаж хэвшсэн байна.

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон Гүйцэтгэх захирал эрхлэн явуулдаг.Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактын гэрээнд заасан эрх хэмжээний дотор Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журмын дагуу компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилладаг билээ.

Гүйцэтгэх захирал Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, батлагдсан төлөвлөгөөний биелэлт болон компанийн үйл ажиллагааны тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж, Төлөөлөн удирдах зөвлөл үнэлэлт дүгнэлт өгч түүнийгээ хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлдэг тогтолцоо бүрэн хэвшсэн болно.


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ
ХАРААТ БУС АУДИТОР
Томилох, чөлөөлөх
ЧИГЛҮҮЛЭХ
ТӨЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, чөлөөлөх санал оруулах
Нэр дэвшүүлэх, Тайлагнах
Санал оруулах, Тайлагнах
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
Санал оруулах, Тайлагнах
Сонгох, хөлсийг тогтоох, гэрээг цуцлах
Томилох, чөлөөлөх
Тайлагнах, цалин урамшууллыг тогтоох
Тайлагнах
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО
- БОДЛОГО
- ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
- KPI
ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО
- БОДЛОГО
- ДЭЭД, ДООД ХЯЗГААР
АУДИТЫН ХОРОО
- ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО
- ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
- ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ
Үйл ажиллагаанд хяналт тавих
Тайлагнах
Томилох, гүйцэтгэлийг үнэлэх, чөлөөлөх
Цалин урамшууллыг тогтоох
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС
Тайлагнах
Тайлагнах
Үйл ажиллагаанд хяналт тавих
Тайлагнах
УДИРДАХ
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
Шалгах, зөвлөх

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Лутаагийн Буянбат (ТУЗ-ийн дарга), Түдэвийн Доржготов (ердийн гишүүн), Лувсансамбуугийн Дашмягмаржав (ердийн гишүүн), Даваадашийн Минжмаа (ердийн гишүүн), Жамбаагийн Чимэдцэрэн (ердийн гишүүн), Ганхуягийн Оюунгэрэл (ердийн гишүүн), Батнасангийн Бямбасүрэн (хараат бус гишүүн), Сахъяагийн Итгэл (хараат бус гишүүн), Базаррагчаагийн Сийлэгмаа (хараат бус гишүүн), Шаравын Мөнх-Очир (нарийн бичгийн дарга).

ЛУТААГИЙН БУЯНБАТ

Олон улсын харилцаа, улс төр, эдийн засагч мэргэжилтэй
2005-2007 онд Тахь Жапан ХХК-ийн Захирал
2007 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах

ШАРАВЫН МӨНХ-ОЧИР

Механик инженер мэргэжилтэй
2000-2005 онд Татекс ХХК-ийн Захирал
2005-2010 онд Вестрен Стар ХХК-ийн Зөвлөх
2010-2013 онд Цөмийн энергийн газарт Мэргэжилтэн
2010-2014 онд Тахько (ХК) компанийн ТУЗ-ийн гишүүн
2014 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

БАТНАСАНГИЙН БЯМБАСҮРЭН

Мэргэшсэн нягтлан бодогч мэргэжилтэй
1971-1998 онд Гутлын үйлдвэрт тооцоооны нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогч
1998-2007 онд Ололт Аудит ХХК-ийн Захирал
2007-2017 онд Пантер-мидланд Аудит ХХК-ийн Захирал,
2010 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ-ийн гишүүн

ЛУВСАНСАМБУУГИЙН ДАШМЯГМАРЖАВ

Мэргэшсэн нягтлан бодогч мэргэжилтэй
2007-2012 онд ТБЦДС ТӨХК-нд дэд захирал
2012-2014 онд МАН-ын ес зүйн хорооны нарийн бичгийн дарга
2014-2016 онд Траст Капитал ХХК-ийн захирал
2016-2017 онд Траст Капитал ХХК-ийн зөвлөх
2017 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ-ийн гишүүн

ТҮДЭВИЙН ДОРЖГОТОВ

Инженер, эдийн засагч мэргэжилтэй
1988–1995 онд Оёдлын үйлдвэрийн нэгдлийн Хэлтсийн дарга
1995–2017 онд Татекс(ХХК) компанийн Захирал
2014 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ–ийн гишүүн

САХЪЯАГИЙН ИТГЭЛ

Инженер мэргэжилтэй
2002–2005 онд ДБЯам Мэргэжилтэн
2005–2008 онд ЗТАЖЯам Мэргэжилтэн, Газрын орлогч дарга
2008–2010 онд ИНЕГ–т Ерөнхий менежер
2010–2017 онд Ач Холдинг ХХК–ийн Менежер, Захирал
2012 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ–ийн гишүүн

ДАВААДАШИЙН МИНЖМАА

Философич, Хуульч мэргэжилтэй
1991–1994 онд МУИС–д Багш
1999–2013 онд МИАТ ХК–нд Хуулийн зөвлөх
2013–2017 онд Өмгөөлөгч
2016 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ–ийн гишүүн

ГАНХУЯГИЙН ОЮУНГЭРЭЛ

Бизнисийн удирдлагын мэргэжилтэй
2008–2013 онд Горжес ХХК–ийн Захирал
2013– 2017 онд Дэлхийд Нэртэй Монгол ТББ–ын Тэргүүн
2014 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ–ийн гишүүн



БАЗАРРАГЧААГИЙН СИЙЛЭГМАА

Бизнесийн удирдлагын мэргэжилтэй
2005–2008 онд Кориана Тайм ХХК–ийн Үйл ажиллагааны менежер
2009– 2012 онд Гермес ХХК–ийн Санхүүгийн ахлах
2013–2017 онд Аглут ХХК–ийн Санхүүгийн ахлах
2014 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ–ийн гишүүн

ЖАМБААГИЙН ЧИМЭДЦЭРЭН

Эдийн засагч мэргэжилтэй
1992–1993 онд Тахько (ХК) компанийн Ерөнхий эдийн засагч
1993–1996 онд Тахько (ХК) компанийн Дэд захирал
1996–2010 онд Тахько (ХК) компанийн Гүйцэтгэх захирал
2003–2017 онд Тахь Электроникс ХХК–ийн Гүйцэтгэх захирал
1993 оноос одоог хүртэл Тахько (ХК) компанийн ТУЗ–ийн гишүүн

БАЙНГЫН ХОРООД

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороотой байна.

Тус байнгын хороод нь доор дурьдсан чиг үүрэгтэй байна.

1. АУДИТЫН ХОРОО

Аудитын хороог хараат бус гишүүн даргалах бөгөөд дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, түүнийгээ Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах үүрэг хүлээдэг.

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- Компанийн дүрэмд заасан болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

2. ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий бусад албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

3. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- Компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- Шаардлагатай тохиолдолд хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхээс татгалзах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

Тахько (ХК) компанийн засаглалын бүтэц, тогтолцоо нь Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, компанийн дүрмээр тодорхойлогдож, Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр, дүрэм, журам, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилладаг юм.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх байнгын хороодтой байх бөгөөд тэдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд ажиллаж байна.

Компанийн засаглалыг хөгжүүлж, хэрэгжүүлэх зорилгоор батлан мөрдөн ажиллаж байгаа баримт бичгүүд:

1. Ногдол ашгийн бодлого
2. Төлөөлөн удирдах зовлөлийн үйл ажиллагааны журам
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
7. Мэдээллийн үйл ажиллагааны журам
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам
9. Дотоод хяналтын журам
10. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам

Компанийн тухай хууль, дүрэмд зааснаар санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдох хүн нэрээ дэвшүүлж, саналаа Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороонд гаргадаг. Нэр дэвшүүлэх хороо нэр дэвшигчдийг бүртгэж, тэдгээр нэр дэвшигчид хууль, тогтоомж, дүрэмд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүний шаардлагыг хангаж буй эсэхийг хянаж, шаардлага хангасан нэр дэвшигчийн талаарх санал дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулдаг.

Компанийн дүрэмд зааснаар гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч нь Гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгож томилох бөгөөд захирал нь компанийн Дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактын гэрээнд заасан эрх хэмжээний дотор Төлөөлөн удирдах зөвлөлөөр баталсан Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журмын дагуу компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилладаг юм.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх асуудал, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороодыг байгуулах, тэдгээрийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох асуудал хууль, дүрэмд зааснаар ил тод явагдаж хэвшсэн байна.

Засаглалын дээр дурдсан журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжүүлж ажилласнаар Гүйцэтгэх захирал Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, батлсан төлөвлөгөөний биелэлт болон компанийн үйл ажиллагааны тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж, Төлөөлөн удирдах зөвлөл үнэлэлт дүгнэлт өгч түүнийгээ хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлдэг тогтолцоо бүрэн хэвшсэн.

Тус компанийн засаглалын тогтолцоо, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, стандарт, зөвлөмжийн дагуу хэрэгжиж байгаа болно.

Компани өөрийн засаглалын бодлого, журам, үйл ажиллагааны хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК–д тухай бүрт нь мэдээлж, тайлагнахын зэрэгцээ олон нийт, хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор батлсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”–ийн дагуу мэдээлж ирсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 2017 онд 7 удаа хуралдсан бөгөөд хурлын ирц 93.65%–тай байсан.

2017 оны ТУЗ–ийн хурлын хуваарь, гишүүдийн оролцсон байдал

№	НЭР	ХУРАЛ							НИЙТ	ИРЦ
		1	2	3	4	5	6	7		
1	Л.Буянбат	1	1	1	1	1	1	1	7	100%
2	Б.Бямбасүрэн	1	1	1	1	1	1	1	7	100%
3	Д.Дашмягмаржав	1	1	1	1	1	1	1	7	100%
4	Т.Доржготов	1	1	1	1	1	1	1	7	100%
5	С.Итгэл	1	1	1	1	1	1	1	7	100%
6	Д.Минжмаа	1	1	1		1	1	1	6	85,7%
7	Г.Оюунгэрэл	1	1	1		1	1	1	6	85,7%
8	Б.Сийлэгмаа	1	1	1	1	1	1	1	7	100%
9	Ж.Чимэдцэрэн	1	1	1			1	1	5	71,4%

НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлсан “Ногдол ашгийн бодлого”–ын баримт бичигт заасан журмын дагуу хуваарилдаг бөгөөд 1992–2017 онд хувьцаа эзэмшигчдэд 1,014,268,2 мянган төгрөгийн ногдол ашиг хуваарилан олгосон.

Тахько (ХК) компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой түвшинд байлгаж, нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг өмнөх жилийнхээс бууруулахгүй байх бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж, 2005 оноос эхлэн жил тутам ногдол ашиг хуваарилах зорилтоо хэрэгжүүлэн ажиллаж байна.

2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
16.25	18.12	36.00	45.00	56.00	56.00	56.00	56.00	56.00	82.00	108.00	108.00	108.00

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаасны зах зээлийн мэдээлэл

Хувьцааны арилжааны дундаж ханш (төгрөг)	10,055.60	11,628.83	20,505.64	18,112.15
Хувьцааны дансны үнэ (төгрөг)	1,901.82	11,770.5	12,214.01	12,091.19
Хувьцааны хаалтын ханш (жилийн эцсийн)	11,000	16,990	21,840	18,480
Хувьцаа эзэмшигчдийн тоо	624	623	623	623
Хувьцааны төвлөрлийн хувь	83.93%	83.93%	83.93%	83.93%

Хувьцааны ханшийн график (2000–2018 он)

Хувьцааны ханшийн график сүүлийн нэг жилээр (2017–2018 он)

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Тахько (ХК) компанийн удирдлагын баг нь Гүйцэтгэх захирал, Захиргааны албаны дарга, Техник үйлчилгээний албаны дарга, Менежер, Ерөнхий нягтлан бодогч, инженер зэрэг эрх бүхий албан тушаалтнуудаас бүрддэг.

ЛУТААГИЙН ЭНХНАСАН
Гүйцэтгэх захирал

ЦЭГМИДИЙН ДОРЖГОТОВ
Захиргааны албаны дарга

ЖАВЗМААГИЙН ГАНХУЯГ
Техник үйлчилгээний албаны дарга

ЭРДЭНЭЧУЛУУНЫ ЧУЛУУНТОГТОХ
Менежер

ГЭНДЭНГИЙН ЭРДЭНЭЧИМЭГ
Ерөнхий нягтлан бодогч

МАХЗАНЫН БАЯНЖАРГАЛ
Инженер

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСИЙН БИЗНЕС

Тахько (ХК) компани нь Нийслэлийн нутаг дэвсгэрийн 1 дүгээр бүс буюу Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороонд хамаарах нутаг дэвсгэрийн 11,880 метр квадрат талбай бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай газар, мөн 1 дүгээр бүс буюу Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд харьяалагдах 5,650 метр квадрат талбай бүхий аж ахуйн зориулалттай газар, нийслэлийн 3 дугаар бүс буюу Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо (Гүнт)-нд байрлах 10,725 метр квадрат талбай бүхий зуслангийн зориулалттай газар (нийтдээ 28,255 метр квадрат талбай бүхий газар)-ыг тус тус эзэмшдэг, 9,080.54 метр квадрат талбай бүхий (контор, үйлдвэрлэл, үйлчилгээ, агуулах, гараж зэрэг зориулалтаар баригдсан 1-4 давхар барилга) үл хөдлөх хөрөнгөтэй, дулаан, усны төвлөрсөн, цахилгаан тэжээлийн нэгдүгээр зэрэглэлийн хангамжид холбогдсон инженерийн байгууламжтай, орчин үеийн холбоо, интернетийн сүлжээгээр тоноглогдсон ажлын байртай юм.

Тус компани нь 2005 оноос үл хөдлөх хөрөнгийн түрээс, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлж, Мобиком корпораци ХХК, Скайтел ХХК, Ньюком проперти ХХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэг дор төвлөрүүлж, гар утас, компьютер, түүний дагалдах хэрэгслийн худалдаа, үйлчилгээний ТЕДИ төв, Скайтел компанийн үйлчилгээний загвар төвийг өөрийн байранд ажиллуулж, Нийслэл хотын үйлчилгээний зах зээлийн хэрэгцээг ханган ажиллаж байна.

Манай компанийн түрээсэлдэг үл хөдлөх хөрөнгө нь чанар, байршил, дэд бүтэц, дотоод зохион байгуулалт, үйлчилгээний байрны зай багтаамж, түрээсийн үнэ, хүн амын хөдөлгөөн төвлөрсөн байдлаар бусад үл хөдлөх хөрөнгийн түрээслэгчдээс давуу бөгөөд нийслэлийн болон орон нутгийн иргэдэд танигдсан, үйлчлүүлэгч бүхэн зорин ирдэг газар нь ТЕДИ төв болсон байна.

МОБИКОМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Мобиком корпораци нь Тахько (ХК) компанитай сүүлийн 13 жил хамтран ажиллаж байгаа бөгөөд урт хугацаанд батлагдсан найдвартай түнш юм.

Мобиком Корпораци нь 2011 онд Монгол Улсын Мэдээлэл харилцаа холбооны салбарын байгууллагууд дотроос анх удаа Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008 стандарт, 2012 онд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2005 стандартыг хэрэгжүүлэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг харилцаа холбооны салбарын тэргүүлэгч компанийн нэг юм. Тус компани нь хувийн хэвшлийн шилдэг менежмент, техник технологийн шийдлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж, нийгэмд тулгамдаад байгаа асуудлуудын талаар Нийслэлийн иргэдийн санал хүсэлтийг Лавлагаа мэдээллийн төвөөрөө хүлээн авч, хотын удирдлагуудын шийдвэр гаргах түвшинд саналыг хүргэж, нийгмийн даатгалын лавлах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдэд ойртуулах тал дээр амжилттай хамтран ажиллаж байгаа компани юм.

Мобиком Корпораци нь дэлхийд тэргүүлэгч чанарын стандартын байгууллага болох Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO) Олон улсын чанарын менежментийн сертификатыг авч, ISO 9001:2008 гэрчилгээг 2014 оноос дахин 3 жилийн хугацаатайгаар сунгуулж, уг стандартыг Теди төвийн үйлчилгээнд нэвтрүүлж ажиллаж байгаа билээ.

Мобиком Корпорацийн хэрэглэгчид дэлхийн 176 орны 500 орчим операторын роумингийн сүлжээнд өөрийн дугаар бүхий гар утсаа ашиглах боломжтойн дээр, 200 орчим улс руу олон улсын 003 шууд гарцаар гадаад дуудлага хийх боломжтой юм. Хэрэглэгч үйлчлүүлэгчдэд зориулан Мобиком үйлчилгээний төвөөр дамжуулан iPhone, Samsung, Nokia, Blackberry, Sony брэндийн гар утсыг албан ёсны эрхтэйгээр Монголын зах зээлд борлуулж байгаа болно.

Мөн Мобиком Корпораци нь өөрийн үндсэн сүлжээгээ дэлхийн хөдөлгөөнт холбооны системд хамгийн өргөн хүрээнд ашиглагддаг GSM системийн сүүлийн үеийн тоон технологийн тоног төхөөрөмжөөр тоноглож, бизнесийн хамтын ажиллагааны хүрээнд Alcatel, Comverse, Ericsson, NEC, NTT, Ceril–lion, AT&T, Comfone, MACH зэрэг дэлхийн нэр хүндтэй компаниудтай түншилж ажилладаг нь хэрэглэгчдэдээ чанартай сайн үйлчилгээг хүргэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэх баталгаа болдог гэж хэлж болно.

ТЭДИ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

“Ньюком Проперти” ХХК–ийг анх 2005 онд “Ньюком групп”–ийн үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээний менежементийг хариуцан гүйцэтгэх зорилготой байгуулж, 12 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өнөөдөр тус компани нь 200 гаруй чадварлаг, мэргэшсэн баг бүхий ажилтан, албан хаагчтай, хэрэглэгч бүрийн сэтгэлд бүрэн нийцэж чадсан, энэ салбарынхаа тэргүүлэгч компани болтлоо өргөжин тэлсэн байна.

Тахько (ХК) компанитай 2014 оноос эхлэн Теди төвийн 2,3,4 дүгээр давхрын ерөнхий түрээсийн гэрээ байгуулан, тус үл хөдлөх хөрөнгийн менежментийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа билээ. Дээрх төвийн гэрээт борлуулагчдаар дамжуулан хэрэглэгчдэд гар утас, компьютер, тэдгээрийн дагалдах хэрэгслийн худалдаа, үйлчилгээг үзүүлж байгаа юм.

Тус компани нь өнөөдөр Ньюком Группийн компаниуд төдийгүй гадны томоохон байгууллага, обьект, хувь хүмүүсийг хамарсан үл хөдлөх хөрөнгийн менежментийн болон түрээсийн иж бүрэн цогц үйлчилгээг явуулж байгаа болно.

Өнөөдрийн байдлаар “Ньюком Проперти” ХХК нь Улаанбаатар хот даяар 20’000 орчим м.кв талбайд худалдаа, үйлчилгээ, оффисын зориулалттай барилгуудыг гадаад дотоодын нэр хүнд бүхий томоохон байгууллагуудад түрээслүүлэн, тэдний тав тух, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан цогц үйлчилгээгээ үзүүлж байна.

СКАЙТЕЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

“Тэнгэрийн Холбоо” нэртэй СКАЙтел компани нь 1999 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр, үүрэн холбооны салбарт жинхэнэ шударга өрсөлдөөнийг бий болгож чадсан компани юм. Өнөөдөр СКАЙтел компани чанарын удирдлагын ISO9001:2008 стандартыг хэрэгжүүлэгч, Монголын 100%–ийн хөрөнгө оруулалттай Үндэсний групп компанийн түвшинд хүртлээ өргөжин, Монгол орон даяар 41 үндсэн салбар, 26 гэрээт салбар, 5300 гаруй гэрээт борлуулагчдаараа дамжуулан, хэрэглэгчдэдээ үйлчилгээний шинэ хэв маягаар, тав тухтай орчин нөхцөлд үйлчилж, хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг өндөр байлгахын төлөө ажиллаж чаддаг компани юм.

СКАЙтел компани нь 2014 онд манай компанитай ерөнхий түрээсийн гэрээ байгуулж МА–I барилгын 1,2 давхарт СКАЙтел үйлчилгээний төвийг шинээр ашиглалтанд оруулсан билээ.

Түс төвөөр дэлхийн 240 орчим орны 760 гаруй операторын сүлжээнд өөрийн дугаараасаа холбогдох боломжтой олон улсын роумингийн цогц үйлчилгээ, олон улсын ярианы World call 002 гарц, утасгүй интернэтийн үйлчилгээ, мөн технологийн дэвшлээр дэлхийд жишиг тогтоогч Samsung, LG, Nokia зэрэг брэндийн гар утсыг албан ёсны эрхтэйгээр худалдах зэрэг үйлчилгээг үзүүлж байгаа юм.

СКАЙтел компани нь хамгийн өндөр хурдны, өргөн зурвасын хөдөлгөөнт интернэтийн сүлжээг Монгол орны 21 аймаг, 350 орчим сум сууринд байгуулсан бөгөөд Монголын №1 Дата оператор болох СКАЙтелийн хэрэглэгчид бусад операторуудын дунджаас хэд дахин илүү дата хэрэглээтэй байдаг байна.

АНКОР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

2015 онд компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор МА–3 барилгыг бизнес, соёл урлаг, бүхий л салбарын үйл ажиллагаа болон олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ буюу хурал зөвлөгөөн, семинар, хүлээн авалт, үзэсгэлэн зэргийг зохион байгуулах чадвартай сүүлийн үеийн тоног төхөөрөмж, орчин үеийн шийдэл бүхий засал чимэглэлтэй АНКОР төвийг байгуулж, амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа билээ.

АНКОР төв нь зориулалтын гэрэл тусгал, хөгжмийн систем, электрон тоног төхөөрөмж, дэлгэц, тайзнаас гадна толин ханатай өвөрмөц засал шийдэлтэй 204 м2 бүхий 70–150 хүн хүлээн авах хүчин чадалтай танхим, хурлын өрөө, кофе шоптой катеринг үйлчилгээг үзүүлэх боломжтой цогц төв болсон юм.

2017 онд Анкор төвд үйл ажиллагааны чиглэлийн дагуу (сургалт, семинар 20, хурал уулзалт 12, урлаг соёлын арга хэмжээ 5, баяр ёслолын арга хэмжээ 16, шагнал гардуулах ёслол 3 , үзэсгэлэн худалдаа 3 зэрэг) нийт 59 удаагийн, 707 цагийн арга хэмжээ зохион байгуулж ажилласан юм.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД







Үндсэн үйл ажиллагааны буюу борлуулалтын орлого (мянган төгрөгөөр)
1 880 382,1
3 011 420,2
3 081 346,7
3 159 639,6
2014 он
2015 он
2016 он
2017 он


Түрээсийн орлого байгууллагаар (хувиар)
Мобиком Корпораци ХХК 24%
Бусад (Ганжжав, Монгол Асейн) 0%
Ньюком Проперти ХХК 53%
Скайтел ХХК 23%


Компанийн татварын дараах цэвэр ашиг (мянган төгрөгөөр)
Татварын дараах ашиг (цэвэр)
Нийт зардал
Нийт орлого
2017 он
790 062
2 607 721
3 493 607
2016 он
507 750
2 755 803
3 334 206
2015 он
361 772
2 788 695
3 201 205

2018 ОНЫ ҮР ДҮН БОЛ МАНАЙ КОМПАНИЙН СТРАТЕГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОВЧТОЙ БАЙДАЛ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ЮМ.

ОРЛОГО ҮР ДҮН		2016	2017	ӨӨРЧЛӨЛТ
Цэвэр борлуулалтын орлого	мян.төг	3,081,347	3,159,640	+2%
Үйл ажиллагааны ашиг	мян.төг	589,917	668,906	+13%
Цэвэр ашиг	мян.төг	507,749	790,062	+56%

БАЛАНС				
Нийт хөрөнгө	мян.төг	14,487,147	14,465,587	–0,1%
Нийт өр төлбөр	мян.төг	77,267	106,416	+38%
Нийт эздийн өмч	мян.төг	14,380,731	14,388,320	+0,05%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	мян.төг	14,487,147	14,465,587	–0,1%

МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	мян.төг	594,109	1,117,764	+88%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	мян.төг	(222.605)	(37.597)	–83%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	мян.төг	(115.666)	(115.666)	0%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	мян.төг	76,894	(3,430)	–96%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	мян.төг	332,732	961,071	+289%

ТАТВАР ТӨЛӨЛТ				
ОАТ	мян.төг	84,989	102,988	+21%
НӨАТ	мян.төг	272,413	288,836	+6%
Бусад	мян.төг	300,555	267,439	–11%
Нийт	мян.төг	657,957	659,263	+0,2%

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Сүүлийн жилүүдэд манай компанийн хувьд амжилт бүтээлээр дүүрэн, хөгжиж дэвшсэн он жилүүд байсан ба 2017 он ч бидний хувьд мөн л амжилтаар дүүрэн жил болж өнгөрсөн бөгөөд компанийн татварын дараах ашиг өмнөх жилээс 48 хувиар нэмэгдлээ. Өнгөрсөн жил компанийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор Мобиком корпораци ХХК–тай байгуулсан түрээсийн гэрээг 5 жил, Ньюком проперти ХХК, Скайтел ХХК–тэй байгуулсан түрээсийн гэрээнүүдийг тус тус 3 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн сунгаснаар компанийн үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, түрээсийн орлогыг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүллээ.

- 2017 оны компанийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)–ын дагуу гаргаж, PwC аудит компаниар олон улсын түвшний бүрэн хэмжээний хараат бус аудитын дүгнэлт гаргуулж, түүнийг Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлснээр санхүүгийн тайланг олон улсын жишгээр тайлагнаж эхэлсэн Монголын хувьцаат компаниудын нэг болж чадлаа.

- Бид Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу Гэгэрэ Эстимэйт ХХК–аар компанийн нийт үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Үнэлгээний олон улсын стандартын дагуу үнэлүүлэх ажлыг хийлгүүлж, жилийн эцсээр данс бүртгэлд тусгалаа. Үнэлгээнд орлого, өртгийн хандлагуудыг ашигласан бөгөөд Монгол улсын эдийн засгийн байдал, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн байдал, түрээсийн зах зээлийн өнөөгийн үнэ, хандлага, зах зээлийн нийлүүлэлт, эрэлт зэргийг компанийн үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг өнөөдрийн бодит байдалтай нийцүүллээ. Цаашид ч бид энэ чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах болно.

2017 ОНЫ ИХ БОЛОН УРСГАЛ ЗАСВАРУУД

Компаний өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2017 онд МА–II барилга (ТЕДИ төв)–ын 3 дугаар давхрын цонх солих засварын ажлыг гүйцэтгэгч “Саран инж девелопмент” ХХК–аар, 4 дүгээр давхрын цонх солих засварын ажлыг Пи Ар Эс ХХК–аар тус тус гүйцэтгүүлж, капиталжуулсан юм.

МА–II барилгын 3, 4–р давхруудын цонх солих их засварын ажил

МА–II барилгын 3, 4–р давхруудын цонх солих их засварын ажил

Түүнчлэн U–I барилгын гадна фасадыг хөөсөн хавтангаар дулаалж, өнгөлөх их засварын ажлыг Азийн идэр цамхаг ХХК–аар, уг барилгын дээврийн парпет, цонхны хаялгын төмөр тавцан хийх ажлыг Арвинзол констракшн ХХК–аар хийж гүйцэтгүүлсэн юм.

U–I барилгын гадна фасадыг дулаалах, өнгөлөх их засварын ажил

Мөн компанийн МА–I, МА–II, МА–III барилгуудын цахилгааны тоолууруудыг засч, шинэчлэх, баталгаажуулах, гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй гэрлээр солих зэрэг цахилгааны урсгал засварын ажлуудыг, компанийн 6 кВ ба 0.4 кВ хуваарилах байгууламж, ХТП 477 дэд өртөөний засвар, үйлчилгээний ажлыг, цахилгааны урсгал засваруудыг хийж гүйцэтгүүлж, өдөр тутмын хэвийн ажиллагааг хангаж ажилласан юм.

Урсгал засварын ажлууд

Бүх барилгуудын дулааны гаднах төв худгийн хаалт солих, 1 ба 2 дугаар контурын ялтсан бойлерын угаалтын ажил, U–I барилгын халаалтын хуучин шугам хэсэгчлэн солих, дулаан, усны тоолуур баталгаажуулах, МА–II барилгын халаалтын шугам, дулааны систем, салбар худгуудын угаах, МА–I, МА–II, МА–III барилгуудын сантехникийн урсгал засварын ажлыг гүйцэтгүүлж, дулаан, цэвэр бохир усны системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

МА–I барилгын төв хаалганы гаднах шатны гишгүүр, хажуу хамар хана засварлах, МА–II барилгын агааржуулалтын системийг шинэчлэх, цонхны хамгаалалт хийх, Анкор төвд кондейшн, хулгайн дохиолол тавих, Гурвалжин дахь аж ахуйн хашааны талбай, харуулын байрны засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

БҮХ ТӨРЛИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжих зорилгоор бүх төрлийн хог хаягдал, нүүрснээс шингэн түлш болон цахилгаан гаргах төслийг эхлүүлж, төслийн зах зээлийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусгах шатандаа явж байгаа бөгөөд эхний ээлжинд төслийн дэд төсөл болох хаягдал тосыг боловсруулж сайжруулсан түлш хийх төслийн бэлтгэл ажлыг хангаад байна.

Бүх төрлийн хог хаягдлыг дахин боловсруулах төслийн 1-р үе шат болох Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэгт хэрэгжих "Хаягдал тос, мазут, дизель боловсруулж сайжруулсан түлш болон цахилгаан үйлдвэрлэх төсөл"

Төслийн нэр	Улаанбаатар хотод байрлалтай компанийн өөрийн эзэмшлийн газарт байгаль орчинд ээлтэй ааргаар "Хаягдал тос, мазут, дизель боловсруулж сайжруулсан түлш болон цахилгаан үйлдвэрлэх төсөл".
Төслийн тодорхойлолт	Тахько (ХК) компанийн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах өөрийн эзэмшлийн газарт хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл нь хаягдал тос, мазут болон дизель түлшийг боловсруулж сайжруулсан түлш, цахилгаан үйлдвэрлэх онцлоготой.Төслийн зорилго нь дотоодын зах зээлийг чанартай, найдвартай, хямд шатахуун болон цахилгаанаар хангахад оршино.
Төслийн нийт өртөг	812.004 сая төгрөг (Тоног төхөөрөмж, барилга байгууламж, тээвэр, дэд бүтэц орсон)
Шаардлагатай түүхий эд	611,298 литр хаягдал тос, мазут, дизель/жилд (Жилд 348,702 литр ус болон 2,880 литр сайжруулах бодис шаардлагатай)
Жилд үйлдвэрлэх сайжруулсан түлшний хэмжээ	960,000 Литр /жилд (2.9кЛитр/хоногт Нийт үйлдвэрлэсэн түлшний 8.8%-ийг цахилгаан гаргахад ашиглана)
Жилд үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ	322.37МВтц/жилд (Төхөөрөмжийн өөрийн хэрэгцээнд 6кВт цахилгааныг ашиглана)

Жилд бууруулах нүүрсхүчлийн хийн хэмжээ	370.72тонCO2 тэнцэх/жилд (Төсөл) (Төвийн эрчим хүчний сүлжээний нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын коэффициент: 1.15 тонCO2тэнцэх/МВтцагт)
Төслийн байршил	Гурвалжин, Хан–Уул дүүрэг
Төслийн хэрэгжилт	Үйлдвэрийг 2018 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөж байгаа болно. Шийдвэрлэх гол асуудал нь үйлдвэрлэсэн шингэн түлш, цахилгааныг борлуулах үнийг тохирох.
Төслийн санхүүжилт	Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага “ЖАЙКА”–гийн хөнгөлөлттэй зээл болон компанийн өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Тахько (ХК) компанийн баримталж буй бодлого, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үргэлж нийгэм, эдийн засагт үнэ цэнэ, баялаг бүтээхэд чиглэж, “Тогтвортой хөгжил”–ийн үндсэн суурь зарчим болох Эдийн засаг, Нийгэм, Байгаль орчны тэнцвэртэй хөгжлийг хангахад, урт хугацаанд үр ашигтай ажиллахыг зорилгоо болгон ажиллаж байна.

Эдийн засаг

- Оролцогч талуудад үр ашгийг хүртээмжтэй байдлыг хангах
- Бүтээмжийг дээшлүүлэх замаар үр ашгийг нэмэгдүүлэх баялаг бүтээх
- Зардлыг бууруулах замаар үр ашгийг нэмэгдүүлэх

Нийгэм

- Шударга ил тод өрсөлдөөний зарчимд тулгуурлан ажиллах
- Хууль эрхзүй, ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн ажиллах
- Үл ялгаварлал, шударга байдлыг эрхэмлэх
- Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хүний хөгжил, байгаль экологид ээлтэй төсөл хөтөлбөр, үйлдвэлэлийг дэмжих хэрэгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах

Байгаль орчин

- Орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах, дахин ашиглахад зориулж төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
- Эрчим хүчийг хэмнэх
- Байгаль орчинд ээлтэй ажил үйлчилгээ явуулах
- Байгаль орчны талаарх Монгол улсын хууль тогтоомж, үндэсний стандартыг мөрдөх

ЭДИЙН ЗАСАГТ ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Тахько (ХК) компани нь 2017 онд Монгол улсын нэгдсэн төсвийн орлогод 659,263 мянган төгрөгийн татварыг төвлөрүүлэн ажиллалаа.
- 2017 оны үйл ажиллагааны ашгаас 128,518.2 мянган төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.

БАЙГАЛЬ ОРЧИНД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай компани нь Байгаль орчинд ээлтэй техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар байгальд ээлтэйгээр үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэн ажилладаг. 2017 онд бид байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлийн хүрээнд дараах ажлуудыг хийж ажилласан байна.

Төсөл хөтөлбөр

Компанийн Хан-Уул дүүрэг 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах газар дээр автын хаягдал тосыг орчин үеийн дэвшилтэт технологиор боловсруулж, олон улсын чанар стандарт хангасан БАЙГАЛЬ ОРЧИНД ээлтэй Эко дизель түлш үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Эрчим хүчний хэмнэлт

Эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх нь улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ард иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2017-2022 онд хүртэлх "Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд цахилгаан эрчим хүчийг өмнөх оноос 2017 онд 4.16 хувиар хэмнэж ажилласан.

Усны хэмнэлт

Барилгын цэвэр усны хэрэглээг бууруулах ажлын хүрээнд усыг зүй зохистой хэрэглэх, үр ашигтай ашиглуулах зарцуулахад анхаарч тодорхой хэмжээний ажлууд хийсэн бөгөөд түүний хүчинд 2017 оны цэвэр усны хэрэглээг 8.46 хувиар бууруулж хэмнэж ажилласан.

НИЙГЭМ БА ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улс орон болон компанийн хөгжлийн гол хүчин зүйл нь хүний хөгжил юм. Компанийн ажилтнуудын авьяас чадвар, нөөц боломжуудыг нээх, хөгжүүлэх, санаачлагатай ажиллах, тавигдсан зорилгыг биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтны хувийн чадварыг мэдэрч, оновчтой ашиглах чиглэлээр хүний нөөцийн менежментийн үйл ажиллагаа явуулж байна.

Ажилчдадаа чиглэсэн:

- Эрэг хандлагыг түгээх, дэлгэрүүлэх сурталчлах үйлсэд хувь нэмрээ оруулах
- Шинэ санал, санаачлагыг дэмжих
- Мэдээллийн урсгалыг сайжруулах

Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа

Компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлд тулгуурлан хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, судалж сонгох, ажилд томилох, сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах, мэргэжлийн ажилтнуудын тогтвортой үйл ажиллагааг хангах, тэдгээрийн албан тушаалыг залгамжлах хүмүүсийг тодорхойлох бодлого баримталдаг.

Оффисын ажилтнуудын эрхэлсэн ажлын болон эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, боловсруулж байгаа асуудлын чанарыг дээшлүүлэх, хууль эрх зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөхөд өдөр тутмын туслалцаа, зөвлөмжөөр хангаж, тэднийг хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Ажиллагсдын байнгын ажлын байрны тодорхойлолтыг албан тушаал бүр дээр нарийвчлан хийж, Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, мөрдөж ажилласнаар ажилтнуудын ажлын байрны зорилго, гүйцэтгэх чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, өдөр тутам харилцах субьект, ажлын байранд тавигдах шаардлага тодорхой болж, ажилтнаас өөрийгөө өсгөж хөгжүүлэх, ажил үүргийг үнэлж дүгнэх, хяналт тавихад ач холбогдолтой болсон.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу компанийн ажлын байрны албан тушаалын жагсаалтыг зохион байгуулалтын нэгжээр хийж, албан тушаалын зэрэглэлийг 5 ангилалтай болгож, тухайн ангилалд хамаарах албан тушаалын лавлах, албан тушаал бүрийн тодорхойлолтыг шинэчлэн мөрдөж, хяналт тавьж ажилласан.

Хөдөлмөрийн гэрээний үндсэн нөхцөл, ажил олгогч ба ажилтны хүлээх үүргийг шинэчилж, цалин, үүрэн холбооны утасны зардалд өөрчлөлт оруулж, хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн боловсруулж, ажиллагсдаас санал авсны үндсэн дээр өмнөх хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, байнгын ажлын байрны 27 ажилтантай шинэчилсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг улирал тутам дүгнэн ажиллаж байна.

Компанийн Хөдөлмөрийн дотоод журам, бусад журмыг нээлттэй танилцуулж, хөдөлмөрийн харилцаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, удирдлагын баг ажилтан хоорондын зөв харилцаа, харилцан бие биенээ ойлголцох, нийт ажилтнуудын дунд найрсаг уур амьсгал бүрдүүлэхэд анхаарал тавин ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн хамт олны эв нэгдэл, алба нэгжийн хоорондын уялдаа холбоог илүү сайжруулах, улмаар ажлын төлөвлөлтийг үр дүнтэй зохион байгуулах, шинэ санаа бүтээлч хандлагыг дэмжих, харилцан суралцаж, туршлага солилцох боломжийг бүрдүүлэхэд компанийн зүгээс ихээхэн анхаарч ажиллахыг эрмэлздэг.

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх

Тус компани Оёдлын артель, фабрик, Оёдлын үйлдвэрийн нэгдлийн үед ажиллаж байгаад гавьяаны амралтаа эдэлж буй 300 гаруй ахмад настантай, тэдний бүртгэл, хүндэтгэл, тусламж үзүүлэх ажил хариуцсан 3 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус Ахмад настны зөвлөл ажилладаг. Компани ахмад настны сан байгуулж, нийт ахмадуудыг ахмадын өдрөөр, 70 ба түүнээс дээш насны ахмадуудыг цагаан сарын үеэр хүлээн авч хүндэтгэл үзүүлж байна

Компанийн зуны аялал

Монгол орныхоо үзэсгэлэнт сайхан байгальд аялан амрах, хамт олны уур амьсгалыг бэхжүүлж, нэгдмэл байдлыг хадгалах зорилгоор компанийн бүх ажилчдыг аялалд хамруулах үйл ажиллагааг жил болгон тогтмол зохион явуулж байна.

Эрүүл ажилтан хөтөлбөр

Компанийн зүгээс ажилтнуудаа жилд нэг удаа магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын стандартын шаардлагыг хангасан үйл ажиллагаа явуулдаг СӨҮЛ СОНГДО эмнэлэгт нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх багц шинжилгээ урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллалаа.

Мод тарих үндэсний өдөр

Ногоон Монголын төлөө нэгдье уриан дор “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”–ийг тохиодуулан компанийн Гүнт дэх хашаанд моджуулах аяныг хэрэгжүүлсэн ба 115 ширхэг гацуур мод тарьж, өмнөх жилд тарьсан модыг арчилж, ургалтыг нэмэгдүүлэх ажлыг хийсэн болно.

Хүүхдийн баярт зориулсан

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан асрамжийн газрын 100 хүүхдийг баярлуулах “Ижий дэлхийн үрс” арга хэмжээг АНКОР төвд зохион байгуулж ивээн тэтгэж оролцов.

Ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Чингэлтэй Дүүргийн Засаг Даргын тамгын газраас зохион байгуулсан алдарт эхийн I, II зэргийн одон гардуулах ёслолын ажиллагааг АНКОР төвд зохион байгуулж хамтран ажилласан.

Цагдаагийн байгууллагын аварга шалгаруулах шатрын тэмцээн.

Хувь хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд оюуны хөгжлийг дэмжиж Цагдаагийн байгууллагын аварга шалгаруулах шатрын тэмцээнийг АНКОР төвд зохион байгуулж хамтран ажиллан ивээн тэтгэж оролцов.

Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж төсөл

Компанийн нийгмийн хариуцлагыг хангах хүрээнд НҮБ, Дэлхийн зөн ОУБ, Мобиком корпораци ХХК–тай хамтран Хүйтэн сэрүүн уур амьсгалтай Монгол орны цаг уурын эрс тэс нөхцөл байдалд нийцүүлсэн нөгөө талаас төвлөрсөн цэвэр ус, дулаан, бохирын нэгдсэн системгүйн улмаас хөдөө орон нутгийн сургууль, цэцэрлэгт ашиглагдаж буй модон жорлонгийн хэрэглээг бүрэн халах, сурагч багачууд байнгын халуун хүйтэн усаар гар нүүрээ угаах, усан татуурга бүхий бие засах орчныг бүрдүүлэн хүүхэд багачуудын тав тухтай, аюулгүй орчин нөхцөлд сурч амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх төсөлд хамтран ивээн тэтгэж оролцов.

ШАГНАЛ

ГЭРЧИЛГЭЭ
№ 26
"Тахько" ХК
МОНГОЛ УЛС
УНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБА

ГЭРЧИЛГЭЭ
"ТАХЬКО" ХХК
МОНГОЛ УЛС
УНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБА

ӨРГӨМЖЛӨЛ
"ТАХЬКО" ХХК-д
"ТЭРГҮҮНИЙ ТАТВАР ТӨЛӨГЧ"-өөр
Д.ГАНБОЛД
Улаанбаатар хот
2012.05.09

МОНГОЛ УЛСЫН
НАЙДВАРТАЙ
ТАТВАР ТӨЛӨГЧ
УНДЭСНИЙ ТАТВАРЫН
АЛБА

GOLDEN AWARD
FOR TECHNOLOGY
AND QUALITY
NEW MILLENNIUM AWARD

"ТОР-100"-д
орсыдсоч
50

ТОМООХОН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

MONGOLIAN STOCK EXCHANGE

ҮЦТХТ

CGDC

pwc

MobiCom

SKYtel

NCProperty

Mongol Content

TSEGTS SECURITY

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

MSFA
Mongolian Society of Financial Analysts

ГОЛОМТ БАНК
Сайн сайхны санхүүжүүлнэ

ХААН БАНК
ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД

ЧИНГИС ХААН БАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын дүгнэлт

pwc

Хараат бус аудиторын тайлан

Тахько ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр Тахько ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Компанийн санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй болон санхүүгийн тайлангуудын тодруулга.

Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид иттэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу Компаниас бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Аудитын арга барил

Хураангуй

Материаллаг байдлын түвшин	• Компанийн материаллаг байдлын ерөнхий түвшин 144,600 мянган төгрөг буюу энэ нь нийт хөрөнгийн 1 хувьтай тэнцүү болно.
Аудитын гол асуудлууд	• Барилгын үнэлгээ

Бид энэхүү материаллаг байдлын түвшинг тодорхойлж, санхүүгийн тайлангуудад материаллаг буруу илэрхийлэл байх эрсдлийг тооцсны үндсэн дээр аудитаа төлөвлөсөн. Тухайлбал бид удирдлагын хийсэн томоохон тооцооллуудыг үнэлж цэгнэсэн. Жишээ нь тодорхой бус ирээдүйн үйл явдлын талаарх таамаглалыг агуулсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд юм. Мөн бид гүйцэтгэх удирдлагын хяналтын орчинд нөлөөлөх байдал буюу эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих үйлдлүүд болон залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг батлах нотолгоо бий эсэхийг авч үзсэн.

Бид аудитын цар хүрээгээ компанийн бүтэц, үйл ажиллагаа эрхэлдэг салбар, бүртгэл хөтлөлт болон хяналтын системийг багтаан санхүүгийн тайлангуудыг бүхэлд нь дүгнэхэд хангалттай нотолгоо өгөхүйц, бидэнд үр дүнтэй ажиллах боломж олгох байдлаар тодорхойлсон болно.

Материаллаг байдал

Бидний аудитын цар хүрээнд материаллаг байдал мөн нөлөөлдөг ба аудит нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ материаллаг буруу илэрхийллээс ангид гэсэн үндэслэлтэй баталгаа гаргахад зориулагдсан. Буруу тайлагнал нь алдаа эсвэл залилангаас үүсч болох бөгөөд энэ нь тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр байвал материаллаг хэмээн тооцогдно.

Бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжинд үндэслэн компанийн нийт санхүүгийн тайланд бүхэлд нь хамаарах ерөнхий материаллаг байдлын босгыг тодорхойлж тогтоосныг доорх хүснэгтэнд харуулав. Эдгээрийг чанарын бусад хүчин зүйлүүдийн хамт харгалзаж үзснээр бид аудитын гүйцэтгэх хугацаа, горимуудын цар хүрээг тогтоож буруу илэрхийлэл бий бол тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд хэрхэн нөлөөлөхийг тодорхойллоо.

Компанийн материаллаг байдлын ерөнхий түвшин	144,600 мянган төгрөг (2016: 28,900 мянган төгрөг)
Тодорхойлохдоо ашигласан арга	Нийт хөрөнгийн 1 хувь (2016: татварын өмнөх ашгийн 5%)
Материаллаг байдлын түвшинг тооцсон үндэслэл	*Бид материаллаг байдлын түвшинг тодорхойлох арга барил үндэслэлийг дахин үнэлсэн ба компанийн ашигт байдлаас илүүтэйгээр нийт хөрөнгийг авч үзэх нь илүү тохиромжтой гэж дүгнэсэн. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь үл хөдлөх хөрөнгийн түрээс болно. Иймд компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг Компанийн нийт хөрөнгийн үнэ цэнээр тодорхойлогддог. Татварын өмнөх ашгийн үзүүлэлт нь тайлант хугацаануудад нэлээд хэлбэлзэж, материаллаг байдлын үнэлгээнд тууштай үндэслэлийг өгөхгүй байна. Компанийн нийт хөрөнгийн үзүүлэлт нь санхүүгийн гүйцэтгэлийг илүү сайн илэрхийлдэг бөгөөд жилээс жилд тогтвортой байх тул жишиг үзүүлэлт болгон сонгон авсан болно. Бидний сонгосон 1 хувь нь энэ салбар дахь ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын хувьд хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлын түвшингийн хувьд шалгуурт багтаж байгаа болно.*

pwc

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хувьд тухайн тайлант хугацааны санхүүгийн тайлангуудад хамгийн чухал нөлөө үзүүлэхүйц зүйлсийг хэлнэ. Эдгээр асуудлуудыг бид санхүүгийн тайлангуудыг аудитлах явцдаа болон аудитын дүгнэлт өгөхдөө харгалзан үздэг бөгөөд тусад нь нэмэлт дүгнэлт гаргадаггүй болно.

Аудитын гол асуудлууд	Бидний аудит эдгээр асуудлуудыг хэрхэн авч үзсэн тухай
Барилгын үнэлгээ	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд, шийдлүүд болон бүртгэлийн тооцооллуудыг харуулсан холбогдох тодруулгуудыг санхүүгийн тайлангуудын Тодруулга 3, 4 болон 8-аас харна уу. Компанийн барилгууд нь Компанийн хөрөнгийн хамгийн чухал нөлөө үзүүлэх ангиллыг төлөөлж байдаг. 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар барилгуудын дансны үнэ 10,625 сая төгрөг (дахин үнэлгээний аргыг ашиглан тооцоолсон) байв. 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд 654 сая төгрөгийн дахин үнэлгээний алдагдлыг хүлээн зөвшөөрсөн. Компанийн бүх барилгын үнэлгээг хараат бус хөндлөнгийн үнэлгээчний үнэлэмж дээр суурилсан тодорхойлсон. Үнэлгээнд компанийн өөрийн эзэмшиж буй барилгуудын хувьд өртгийн аргыг, харин түрээслүүлж буй барилгын хувьд түрээсийн үнэлгээг мөнгөн урсгалыг хорогдуулах байдлаар үнэлгээг гүйцэтгэсэн.	Удирдлагын ашигласан үнэлгээний аргачлалыг бид үнэлсэн бөгөөд үнэлгээний арга хэрэгслүүдийг Мэргэжлийн үнэлгээний стандартын дагуу хэрэглэсэн болохыг олж тогтоосон. Үндсэн гол төсөөлөл, тамааглалууд нь холбогдох нотлох баримтуудаар дэмжигдсэн болохыг бид олж тогтоосон. Үнэлгээний загварт ашигласан орцуудад бид нарийвчилсан шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Орцуудад баталгаажсан гэрээ болон дүрэм журмуудад үндэслэгдсэн (Үүнд: түрээсийн нийт талбай, метр квадратад ногдох түрээсийн үнэ, хөрөнгийн татвар г.м) бид барилгуудын тусгай мэдээлэл болон үндсэн гэрээнүүдтэй тэдгээрийг давхар нягталж шалгасан. Ирээдүйн төсөөлөл, таамаглалд (санхүүгийн тайлангийн Тодруулга 4-д) үндэслэсэн орцуудын хувьд тэдгээрийн зохистой байдлыг тухайн барилгуудын түүхэн мэдээллийг зах зээлийн боломжит мэдээлэлтэй (зах зээл дээрх түрээсийн төлбөр болон ашиг орлогыг оролцуулан) харьцуулан бид үнэлсэн.
Барилгын дансны үнийг бодит үнэ цэнээр дахин үнэлсэн нь санхүүгийн тайланд материалаг хэмжээний нөлөөллийг үзүүлж байна. Иймд тус үнэлгээг гүйцэтгэхэд ашигласан ач холбогдол бүхий үнэлэмж, таамаглалууд хамгийн их нөлөөтэй тул бид үүнд анхаарлаа хандуулсан. Тухайлбал зах зээлийн нөхцөл байдлын үнэлэмжүүд, барилга тус бүрийн шинж чанар, байршил, нөхцөл байдал, мөн тэдгээр түрээслэсэн хөрөнгүүдийн хувьд ирээдүйн хүлээгдэж байгаа орлого зэрэг нилээд томоохон нөлөөллийг харгалзан үзсэн. Эдгээр байдлаас шалтгаалан бид аудитын ажлын хувьд энэ хэсэгт онцгой анхаарал хандуулсан болно.	Барилга бүрийн шинж байдал түүнчлэн барилгын ерөнхий чанар, газарзүйн байршил болон нийт хөрөнгийн тохиромжтой байдалд анхаарлаа хандуулсан гэдэгт Удирдлага болон хөндлөнгийн үнэлгээний мэргэжилтнүүдтэй хийсэн харилцан ярилцлагаас нотолгоо болгож авсан. Компанийн барилгуудын үнэлгээ болон тэдгээртэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг хэмжээний онцгой зүйл байхгүй гэж бид тэмдэглэж байна.

pwc

Бусад мэдээлэл

Бусад мэдээллийн хүрээнд компанийн захирлууд хариуцлага хүлээнэ. Учир нь бусад мэдээлэл

Бусад мэдээллийн хүрээнд компанийн захирлууд хариуцлага хүлээнэ. Учир нь бусад мэдээлэл компанийн жилийн тайлангаас бүрдэх боловч бидний аудитын тайлангаа гаргах өдрийг хүртэл олж авсан нотолгоонуудад үндэслэсэн аудитын тайлан болон санхүүгийн тайлангуудыг агуулаагүй байдаг.

Бидний санхүүгийн тайлангуудад өгөх дүгнэлт нь бусад мэдээллүүдэд хамаарахгүй тул бид бусад мэдээллүүдэд ямар нэгэн баталгаа, дүгнэлтийг илэрхийлээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой үүрэг хариуцлагын хувьд, дээр дурдсан бусад мэдээлэлтэй танилцаж эдгээр мэдээллүүд нь санхүүгийн тайлангуудтай болон бидний аудитын явцад олж авсан мэдэгдэхүүнтэй материаллаг байдлын түвшинд нийцэхгүй байгаа эсэх, эсвэл материаллаг байдлын түвшинд буруу илэрхийлэл бий эсэхийг нягталдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор компанийн засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлангуудын олон улсын стандартын дагуу болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэх нь удирдлагын үүрэг бөгөөд мөн ийнхүү бэлтгэхэд шаардлагатай гэж үзвэл дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Компанийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Компанийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Компанийн засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл иттэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.

pwc

- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Компанийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.
- Санхүүгийн тайлангуудыг тодруулгын хамт бүтэц, агуулга, ерөнхий толилуулагын хувьд суурь ажил гүйлгээ болон үйл явдлуудыг илэрхийлж чадан үнэн зөв тайлагналыг хангаж буй эсэхийг үнэлдэг.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын доголдол багтдаг.

Бид мөн хараат бус байдалд тавигдах ёс суртахууны хэм хэмжээний тухай, хараат бус байдалд нөлөөлөх харицаа болон бусад бүхий л нөлөөлөхүйц хүчин зүйлүүдын талаар, шаардлагатай нөхцөл байдалд тэдгээрээс хараат бус байдлыг хэрхэн хамгаалах арга хандлагаа тусгасан мэдэгдлийг засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд гаргаж өгдөг.

Засаглал хариуцсан эрх бүхий этгээдтэй харилцсан зүйлсээд бид тухайн тайлант хугацааны санхүүгийн тайлангуудын аудитад хамгийн чухал нөлөөтэй зүйлсийг буюу аудитын гол асуудлыг тодорхойлдог. Эдгээр асуудлуудыг бид хууль тогтоомжоор олон нийтэд дэлгэхийг хориглосон эсвэл, маш цөөн тохиолдолд, уг асуудлуудыг мэдээллэсэнээс үүсэх таагүй үр дагавар нь олон нийтийн эрх ашигаас илүү өндөр хэмээн үзсэнээс бусад тохиолдолд аудитын тайландаа тусгадаг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын партнер нь Мэттью Поттл болно.

Гарын үсэг зурсан:

Даваагийн Баярмаа
Гүйцэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Мэттью Поттл
Партнер
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

2018 оны 02 дугаар сарын 08 өдөр
Улаанбаатар, Монгол Улс

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тодруулга	31/12/2017	31/12/2016
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	8	11,201,986	11,851,734
Хөрөнгө оруулалт	9	–	33,812
Зээлийн авлага		790	2,470
Биет бус хөрөнгө		5,828	6,763
Нийт Эргэлтийн бус хөрөнгө		**11,208,604**	**11,894,779**
Эргэлтийн хөрөнгө			
Бараа материал	10	39,560	46,495
Урьдчилж гарсан зардал	11	1,685	227,482
Хүүгийн авлага		1,647	45,040
Богино хугацаат зээлийн авлага		–	1,680
Худалдааны авлага болон бусад авлага	12	306,225	324,876
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13	2,907,866	1,946,795
Нийт Эргэлтийн хөрөнгө		**3,256,983**	**2,592,368**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**14,465,587**	**14,487,147**
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	14	199,917	199,917
Хуримтлагдсан ашиг		3,830,571	3,169,027
Эздийн өмчийн бусад хэсэг	15	10,357,832	11,011,787
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**14,388,320**	**14,380,731**
ӨР ТӨЛБӨР			
Эргэлтийн ӨР ТӨЛБӨР			
Худалдааны болон бусад өглөг	17	72,002	95,742
Орлогын болон бусад татварын өр төлбөр	16	5,265	10,674
Өр төлбөрийн дүн		**77,267**	**106,416**
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БОЛОН ӨР ТӨЛБӨР		**14,465,587**	**14,487,147**

ОРЛОГО УР ДҮН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017	2016
Борлуулалтын орлого	18	3,159,640	3,081,347
Борлуулалтын өртөг	19	(919,289)	(1,060,350)
Нийт ашиг		**2,240,351**	**11,894,779**
Ерөнхий ба удирдлагын зардал	20	(1,571,445)	(1,431,080)
Үйл ажиллагааны ашиг		**668,906**	**589,917**
Үйл ажиллагааны бус (зардал)/орлого	21	(39,738)	(130,570)
Санхүүгийн орлого	22	256,718	119,055
Орлогын албан татварын өмнөх ашиг		**885,886**	**578,402**
Орлогын албан татварын зардал	23	(95,824)	(70,653)
Тайлант жилийн ашиг		**790,062**	**507,749**
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ	15	(653,955)	–
Бусад дэлгэрэнгүй орлого тухайн жилийн		**(653,955)**	
Нийт дэлгэрэнгүй орлого тухайн жилийн		**136,107**	**507,749**
Ашгийн хуваарилалт:			
Компанийн эзэд		790,062	507,749
Нийт ашиг тухайн жилийн		**790,062**	**507,749**
Нийт дэлгэрэнгүй орлогын хуваарилалт:			
Компанийн эзэд		136,107	507,749
Нийт дэлгэрэнгүй орлого тухайн жилийн		**136,107**	**507,749**
Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох үйл ажиллагааны ашиг, үндсэн болон хорогдуулсан (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	24	**664**	**427**

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод руулга	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт
2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн үлдэгдэл		199,917	11,011,787	2,789,795	14,001,499
Тухайн жилийн ашиг/(алдагдал)		–	–	507,749	507,749
Тухайн жилийн бусад дэлгэрэнгүй орлого	15	–	–	–	–
2016 оны нийт дэлгэрэнгүй орлого	–	–	–	507,749	507,749
Нэмж гаргасан хувьцаа		–	–	–	–
Зарласан ногдол ашиг	14	–	–	(128,517)	(128,517)
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		199,917	11,011,787	3,169,027	14,380,731
Тухайн жилийн ашиг/(алдагдал)		–	–	790,062	790,062
Тухайн жилийн бусад дэлгэрэнгүй орлого	15	–	(653,955)	–	(653,955)
2017 оны нийт дэлгэрэнгүй орлого	–	–	(653,955)	790,062	136,107
Нэмж гаргасан хувьцаа		–	–	–	–
Зарласан ногдол ашиг	14	–	–	(128,518)	(128,518)
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		199,917	10,357,832	3,830,571	14,388,320

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017	2016
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	23	885,886	578,403
Тохируулгууд:			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	8	366,156	351,590
Биет бус хөрөнгийн хорогдуулалт		1,835	1,638
Худалдааны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын гарз		–	83,695 54,189
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарз		–	23,781
Бараа материалын хасалт		4,783	27,478
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	21	(3,024)	(119,055)
Санхүүгийн орлого	22	(256,718)	(76,894)
Гадаад валютын ханшийн зөрүү	21	3,430	49,454
Үйл ажиллагааны бусад мөнгөн бус зардал		–	
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		1,002,348	974,279
Худалдааны болон бусад авлагын бууралт/(өсөлт)		20,331	(113,152)
Бараа материалын бууралт/(өсөлт)		2,152	(3,641)
Урьдчилж төлсөн төлбөр тооцооны бууралт/(өсөлт)	11	225,797	(222,907)
Худалдааны болон бусад өглөгийн (бууралт)/өсөлт		(23,740)	89,880
Орлогын болон бусад татварын өр төлбөрийн (бууралт)		(6,136)	(45,361)
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт		1,220,752	679,098
Төлсөн орлогын албан татвар		(102,988)	(84,989)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		1,117,764	594,109
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	8	(439,300)	(330,470)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	8	67,000	38,000
Биет бус хөрөнгийн худалдан авалт		(900)	(5,000)
Хүлээн авсан хүүгийн орлого		300,111	74,015
Хөрөнгө оруулалтын борлуулалтын орлого	9	33,812	–
Зээлийн эргэн төлөлт	12	1,680	850
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(37,597)	(222,605)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Компанийн хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашиг		(115,666)	(115,666)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(115,666)	(115,666)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	21	(3,430)	76,894
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,946,795	1,614,063
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,907,866	1,946,795